


**ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АВЛИГЫН ЭСРЭГ 2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1 Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг байгууллагын албан ёсны цахим хуудас, сошиал суваг, дотоод сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн самбар зэрэгт байрлуулж олон нийтэд хүргэх	Төвийн хэмжээнд түгээсэн нийт мэдээлэл, контентын тоо	- ЭХЭМҮТ-ийн авлигаас урьдчилан сэргийлэх, авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр хийх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 23-нд төвийн захирлаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. - Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн дагуу ХАСХОМ мэдүүлэх 52 албан тушаалтны мэдүүлгийг хуулийн хугацаанд нь /2025.02.15/ нэгтгэн баталгаажуулж, ЭМЯ-ны Эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн, Шинээр томилогдсон 14 албан тушаалтны ХАСУМ, ХАСХОМ мэдүүлгийг хуулийн хугацаанд нь мэдүүлсэн. - Авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор АТГ-ын Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газрын веб хуудсыг төвийн www.ehemut.mn веб хуудастай холбон ажиллаж байна. - Төвийн www.ehemut.mn веб хуудсанд Авлигын эсрэг хамтдаа булан нээж, ЭХЭМҮТ-ийн авлигаас урьдчилан сэргийлэх, авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр хийх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, АТГ-аас бэлтгэсэн Авлигын эсрэг нэгдье шторк, инфогрфик, зураг хуудас сурталчигааг байршуулан олон нийтэд хүргэж байна. - ЭБЭЭ, ХЭ-ийн ЯТТ, НҮЗП, ХЗП, төвийн захиргаан гадна самбарт АТГ-аас бэлтгэсэн

				Авлигын эсрэг нэгдье шторк, инфогрфик, зураг хуудас сурталчилгааг байршуулан олон нийтэд хүргэж ажилласан. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” самбар, хүн олноор цуглардаг НҮЗП, ХЗП, ЯТТ-уудын мэдээллийн самбарт Авлигын зурагт хуудас брошур байршуулсан.
		1.2 Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	Өдөрлөгийн үр дүн, оролцогчдын тоо	2025.04.05-нд төвийн нийт 32 ахлах сувилагч нарт “Авилга болон авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх тухай ойлголт мэдээллийг өгсөн. 
		1.3 Авлигын эсрэг хууль тогтоомж, түүний хэрэгжилтийн талаар эрүүл мэндийн байгууллагын холбогдох албан тушаалтнуудад сургалт зохион байгуулах	Сургалтын үр дүн, тайлан, сургалтанд оролцогчдын тоо	- Төвийн ЭБАТ 2025.01.06, 202505.13-нд АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс зохион байгуулсан Авлигын онлайн сургалтанд Төвийн ЭБАТ болон ХАСХОМ бөглөх 52 албан тушаалтан, шинээр томилогдсон 14 албан тушаалтан бүрэн хамрагдсан. - Нийт 66 албан тушаалтан хамрагдсан байна. 2025.09.23-ны өдөр Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтэн , ажил нарт “Авилга, ашиг сонирхлын зөрчил” сэдвээр сургалт зохион байгуулсан. Уг сургалтанд 100 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон

				 Төвийн ЭБАТ 2025 оны 10 дугаар сарын 15, 2025 оны 12 дугаар сарын 01-нд Авлигын эсрэг хууль тогтоомж болон УИХ-ын ХЗБХ-ны 2024 оны 5-р тогтоолын дагуу мэдүүлгийн бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтанд оролцсон.
2	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	2.1 “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	Журмын хэрэгжилтийн үнэлж, хэрэгжилтийг сайжруулахаар авсан арга хэмжээний дүн	Төвийн ёс зүйн салбар хорооны зөвлөлийн олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах зарыг 2025 оны 03 дугаар сард www.ehemut.mn веб сайт дээр байрлуулан 1 хүний материал ирж, Ёс зүйн салбар хорооны зөвлөлийн гишүүнээр томилсон
		2.2 Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах	Ил тод нээлттэй мэдээллэсэн мэдээллийн тоо	- Монгол улсын “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, 2015 оны “Шилэн дансны тухай” хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн төвийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. - Төвийн ЭБАТ-наас Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хагас бүтэн жилээр нэгтгэн шилэн дансанд байршуулах зөвлөмж Санхүү бүртгэлийн алба, Хүний нөөцийн алба, Тендерийн хорооны дарга нарт өгч ажилласан.

				- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн дагуу 8, 9 дүгээр зүйлд заасны дагуу ЭХЭМҮТ-ийн Тендерийн хороо байгуулах тухай 2025 оны А/05, А/10, А/11, А/12, А/13, А/14 тоот тушаал, тендерийн хорооны гишүүдийн ашиг сонирхлын зөрчийн мэдэгдлийг хуулийн хугацаанд нь шилэн дансанд байршуулсан. 2025 оны Тендерийн нээлттэй заруудыг www.tender.gov.mn, ehemut.mn вэб сайт дээрээ байршуулсан.
3	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	3.1 Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байхад байгууллагын удирдлагын баг тасралтгүй хяналт тавих, зөрчил үүссэн нөхцөл байдал яаралтай арга хэмжээ авч ажиллах	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	- ЭБЭЭ-ийн Төрсний дараах тасаг болон төлбөрт өрөөнийн нөхцөлийн хяналтыг сайжруулж, төлбөрийг тухай бүр СНББА-аас тогтмол хяналтыг явуулж байна. - Бэлэн мөнгөөр төлбөр авахгүй, төлбөрийг посоор авах зэрэг төвийн хэмжээнд эрсдэлээс урьдчилан сэргийлж, хариу арга хэмжээ авч ажиллаж байна.
		3.2 Салбарын хэмжээнд гарч буй өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг нэгтгэн гомдлыг шалтгаан нөхцөлийг тодорхойлох	Салбарын өргөдөл гомдлын нэгдсэн тайлан, дүн шинжилгээ	✓ 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар тус төвд ЭМЯ, ЭМГ болон холбогдох яам, газруудаас нийт 1209 албан бичиг ирсэн байна. Үүнээс: ➢ ЭМЯ-наас 295 ➢ Сайдын тушаал, албан даалгавар-32 ➢ Өргөдөл, хүсэлт-118 ➢ 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 11-11 төвөөр нийт 265 өргөдөл, гомдол, хүсэлт, талархал ирсэн байна. Үүнээс Дэмжлэг хүсэхтэй холбоотой 76, бусад-109,
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл,	4.1. Удирдлагын зүгээс 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 1-р улиралд, хэрэгжилтийн	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсах байх, -Албан хаагчдаас гаргасан санал	Төвийн www.ehemut.mn веб хуудсанд Авлигын эсрэг хамтдаа булан нээж, ЭХЭМҮТ-ийн авлигаас урьдчилан сэргийлэх, авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр хийх 2025 оны үйл

	санаачилга өрнүүлэх	явц, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчиддаа танилцуулах,	санаачилгыг хэлэлцсэн байх, -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	ажиллагааны төлөвлөгөө, тайланг ил тод байрлуулан албан хаагчдад хүргэсэн байна.
		4.2 Авлигатай тэмцэх, соён гэгээрүүлэх, эрсдлийг бууруулах чиглэлээр байгууллагын удирдлага шинэ ажил санаачилан хэрэгжүүлж, сурталчлах	Хэрэгжүүлсэн шинэ санал, санаачилгын тоо, хэрэгжилтийн тайлан	2025.09.26-нд Авилгын эсрэг хамтдаа нэгдье видео контент бэлтгэн www.ehemut.mn веб хуудас болон Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв пейж хуудсанд байршуулсан. Тус контент 3100 хүнд хүрсэн байна.  

ТАЙЛАН БИЧСЭН: /ЭХЭМҮТ-ИЙН ЭБАТ Б.БОЛОР/